

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ**  
**(МРЦМ/202102498)**

2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

1. Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилтын төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийн төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу өөрийн эзэмшилд буй MV-016657 тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хамт хийлгэх үйлчилгээ болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга,
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,
  - Тусгай зөвшөөрөл,
  - Сүүлийн 5 жилд уул уурхай, баяжуулах үйлдвэрийн төсөлд БОНБНУ хийж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээ дүгнэсэн акт/,
  - Татварын өргүй тухай тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 11 дүгээр сарын 18–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ